хэрэгжүүлж, нийгэм иргэдийн амгалан тайван байдлыг хангаж байдаг өвөрмөц ажил үүрэг байдаг. Энэ чиг үүргийнхээ дагуу хорих анги олон талт үйл ажиллагаа авч хэрэгжүүлж байдаг тул дарга нар бүх талаар мэдлэг, дадлага эзэмшсэн байх шаарддага нэн тэргүүнд тавигдах нь зүй нь хэрэг юм. Судлаачын хувьд тухайн хүний сэтгэл зүй болон орчны онцлог байдлыг харгалзан ялгавартай хандаж, ажиллах арга барилын дараалал боловсруулж удирдах ажилтаны ажилд тус нэмэр болох болов уу гэж дараах аргачлалыг судалгааны үр дүнд дэвшүүлж байна.

1. Ажиллах объектоо сонгон авч хэнтэй яаж ажиллахаа тогтоон зайлшгүй анхаарал татаж байгаа хэсгийг олж, тэдэнтэй тал бүрээс нь ажиллах. Тухайлбал, залуу, ахмад, тэргүүний алба хаагч, дундач, хамт олноос хоцрогчид гэж ангилан өөр өөр арга барилаар ажиллах. Уг албан хаагчтай ямар арга хэлбэрээр ажиллах нь илүү үр дүнд хүрэхийг урьдчилан тооцож, судлах шаардлагатай болдог юм.

2. Хүнээ судалж үзэсний үндсэн дээр уг хүний шинж байдлыг харгалзан ажиллах арга барилаа сонгодог. Нэг хүн хатуу зарчимч шаардлагад дуртай байхад нөгөө хүн уян зөөлөн харилцахад тааламжгай байх зэргээр хүн бүр өөр өөр өвөрмөц арга барил шаарддаг.

3. Хүн бүртэй өөр өөр аргаар тулж ажиллаад ямар үр дүнд хүрснээ тооцож уг хүнийг идэвхижүүлж хүмүүжүүлснээр хөдөлмөрийн хамт олныг зөв төлөвшүүлэхэд яаж нөлөөлснийг удирдах хүн байнга тооцож, цаашдын зорилтоо тодорхойлдог байх. Үүний үр дүнд хамт олны нийгмийн болон ажлын идэвхи сайжирч, хамт олны дунд аливаа доголдол дутагдал орших орон зайгүй болно.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн 821 дүгээр дамжааны суралцагч,*
*дэд хурандаа Д. Одхүү*

## ТОДОРХОЙ АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХ ХАСАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах ялын тухай ойлголт, түүхэн уламжлал болон тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах ялын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорьсон болно.*

***Түлхүүр*** *үг. Хорихоос өөр төрлийн ял, төрийн алблан тушаал эрхлэх, мэргэжлийн үйл ажиллагаа, эрх хасах.*

2002 батлагдан хэрэгжиж буй Монгол улсын Эрүүгийн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2. дахь хэсэгт тодохрхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг хуульчлан тогтоож улмаар 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт 'Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн төрийн албан тушаал эрхлэх, тодорхой мэргэжлийн болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэгээс таван жил хүртэл хугацаагаар хязгаарлахыг тодорхой албан тушаал эрхлэх, эрх хасах ял гэнэ" хэмээн тодорхойлжээ.

Нэгэнтээ, гавьяат хуульч Б.Чимэд "...эрүүгийн ял хүнд хөнгөндөө биш, зайлшгүй байх ёстой" гэсэн нь хүний заавал хорьж шийтгэх нь чухал биш гэдгийг онцолсон хэрэг болов уу.

Өнөөдөр Монгол Улс эрх зүйн шинэтгэлийнхээ хүрээнд, гэмт хэрэг үйлдэгсдэд хорихоос өөр төрлийн ялыг хэрэглэж, ялтныг аль болох нийгэм олон нийтээс тусгаарлалгүйгээр ялыг эдлүүлэх бодлого баримталж байгаа бөгөөд хорих ял эдэлснээр гэмт хэрэг үйлдэхэд гарших, гэмт явдлын талаар илүү мэдлэгтэй болох явдлаас урьдчилан сэргийлнэ гэж хүлээн зөвшөөрч байна.




*/График 1. ТАТЭҮАЯЭХ ялын биелэлтийн сүүлийн 4 жилийн судалгаа 9 сарын байдлаар/*

Монгол Улсын одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуульд тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ялаар шийтгэх 74 зүйл хэсэг байдаг бөгөөд улсын хэмжээнд сүүлийн 4 жилийн байдлаар судалгаанаас үзэхэд 2012 онд биелүүлбэл зохих 445 гүйцэтгэх хуудаснаас 89 г/х биелүүлж биелэлт 20%, 2013 онд 842 г/х-аас 216 г/х биелүүлж биелэлт 25.7%, 2014 онд 1212 г/х-аас 272 г/х биелүүлж, биелэлт 22.4%, 2015 онд 1506 г/х-ны 410 г/х-г биелүүлж биелэлт 27.2%-тай байна.

Энэ бүхнээс харахад гүйцэтгэсэн ялын биелэлт нь биелүүлбэл зохих гүйцэтгэх хуудасны тооноос хамаарч өссөн үзүүлэлт харагдах хэдий ч гүйцэтгэлийн хувь хэмжээ харьцангүй тогтмол байгаа нь харагдаж байна. Энэ нь, эрх хасах ял өөрөө тодорхой хугацаа заадаг, хоногоор тоолдог тул

шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран сар, улирал, он дамжин үлдэгдэлтэй гардгаас шалтгаалж байна гэж үзлээ. Энд би гүйцэтгэлийг хувилан гаргасан нь шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үзүүлэлтийг уг ялын хувиар тооцдог гэж хэлэх гэсэн хэрэг биш бөгөөд зөвхөн гүйцэтгэх хуудас болон биелүүлсэн гүйцэтгэх хуудасны хоорондын харьцааг л үзүүлэх гэсэн хэрэг болно.

Мөн 2015 оны 9 сарын байдлаар жолооны эрх хасахаас бусад эрх хасах ялын судалгааг графикаас үзвэл

**График 2. Жолоодох эрхээс бусад албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасагдсан байдал (2015 оны 9 сарын байдлаар)**




төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг албан тушаалтнуудын тусгай эрхийг хасах явдал голчилсон байгааг харж болно. Үүний зэрэгцээ уг ялын биелэлтийг хангахад дараах нөхцөл байдлууд нөлөөлж байна.

ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх тасгийн ахлах мэргэжилтэн, НШГА-ны ХӨТЯ эдлүүлэх тасгийн шийдвэр гүйцэтгэгчидтэй уулзан харилцан ярилцах явцад “төрийн байгууллагаас ЦЕГ-ын Лицензийн төв бол жолооны эрх хасах ялыг гүйцэтгэхэд хурдан шуурхай ханддаг бөгөөд нэгдсэн байдлаар жолооны үнэмлэхийг устгалд оруулж мэдээлэл солилцож хамтран ажилладаг юм, харин төрийн бусад байгууллагын удирдах дээд байгууллага нь энэ ялын биелэлтийг хангах тал дээр хараахан зүгширч чадаагүй байна, энэ нь тухайн салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх хасах ял цөөн ирдэгтэй холбоотой болов уу” гэж байгаа нь төрийн болон төсвийн байгууллагын удирдах дээд байгууллага албан тушаалтны энэ эрх хасах ялын биелэлтийг хангах талаархи мэдлэг мэдээлэлийг сайжруулах, ШШГБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг тусламж үзүүлэх үүрэг чиглэлийг нь тодотгож хамтран ажиллах шаардлага байгааг харуулж байна.

Мөн үүний зэрэгцээгээр хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нар нь ажил үүргээ гүйцэтгэх

санхүүгийн зардал байдаггүй зөвхөн байгууллагын төсөвт хөрөнгөд заагдсан зардлаар үйл ажиллагаа явуулж байна.

Мөн үүний зэрэгцээ тэд гүйцэтгэсэн ажлынхаа төлөө урамшуулал авдаггүй билээ. /Бусад шийдвэр гүйцэтгэгчид зардал урамшууллын гэрээ байгуулж ажилладаг/. Иргэний хэргийн шийдвэр хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид нь албанаас гар утсаар хангагдаж, тодорхой лимит дотор үнэ төлбөрийг байгууллага хариуцаж ажил үүргээ явуулдаг байхад хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид ийм хангамж үгүй юм.

Эдгээр нөхцөл байдал нь ялтанд ял завшуулах, үүрэгт ажилдаа хайнга хариуцлаггүй хандах шалтаг болохыг үгүйсгэхгүй юм.

Энэхүү ялын биелэлтийг хангахад дараах хүндрэлтэй асуудал байсаар байна Үүнд:

1. Жолооны эрх хасуулсан ялтан орон нутагт тээврийн хэрэгсэл жолоодож явааг шийдвэр гүйцэтгэгч мэдэх боломжгүй.

2. Эрх хасах ялыг хорих болон баривчлах ял дээр нэмэгдэл ялын чанартай оногдуулсан тохиолдолд гүйцэтгэх хуудсыг шүүгч хэзээ бичиж Шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлж байх талаар нарийвчилсан зохицуулалт байдаггүйгээс хорих болон баривчлах ялыг биечлэн эдлэх хугацаанд гүйцэтгэх хуудас шүүх дээр хадгалагдаж, улмаар тухайн ялтан хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан эсэхийг ялтны оршин суухаар явсан газрын Шийдвэр гүйцэтгэх албанд сулласан хорих анги мэдэгдээгүйгээс нэмэгдэл ялыг эдлүүлэхээр хяналтанд авахгүй байх явдал гарч байна[1]

3. График 2-оос харахад чухам ямар албан тушаал, үйл ажиллагаа явуулах эрхийг нь хассан нь тодорхойгүй зүгээр л “тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах” гэсэн үзүүлэлт байна. Энэ талаар шийдвэр гүйцэтгэгч нараас судлаж тодруулахад “шүүхийн тогтоолын заалт үг үсгээр бичигдэж байгаа, бид энэ талаар шүүхэд асуудал тавьдаг, энэ нь тухайн ялтны яг ямар эрхийг хасаж ял эдлүүлэх вэ гэдгийг тодорхойгүй болгодог, улмаар ажилд хүндрэл бэрхшээл учруулдаг. Бид үүнийг тухайн хүн ямар ажил хийж байгаад ямар гэмт хэрэг үйлдэв гэдгийг тогтоолыг нь үзэж байгаад шийдвэрлэж байна” гэсэн нь бас нэг талын хүндрэл болж байна.

4. Ялыг эдлүүлэх ажиллагааны явцад тухайн ялтныг ажилд авсан, томилсон, сонгосон аж ахуйн нэгж байгууллага ажлаас чөлөөлөх, эрх

[1] *Ш.Сүхбат.* Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам. илтгэл. 2012 УБ.

олгосон шийдвэрээ өөрчлөхгүй байх.явдал нилээд гарч байна[1]. Дээрх нөхцөл байдлыг харгалзан тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял бүрэн утгаараа хэрэгжинэ гэж үзлээ. Үүнд:

1. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялын биелэлтийг хувиар тооцдог байдлыг үйл ажиллагааны мэдээ судалгаа тайлан гаргахад ашиглах, харин шийдвэр гүйцэтгэгчийн ажлын үзүүлэлт болгохгүй байх;
2. Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагааг, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч хариуцан эдлүүлж байгааг өөрчилж тогтоол гүйцэтгэгч хариуцаж байх;
3. Хорихоос өөр төрлийн ялыг биелүүлэхэд иргэний шийдвэр гүйцэтгэлийн адил шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг бий болгох;
4. Эрх хасах ялыг нэмэгдэл ялын чанартай ногдуулсан тохиолдолд Шүүх, хорих анги, шийдвэр гүйцэтгэгч нарын гурвалсан хамтын харилцан ажиллагааны процесс ажиллагааг илүү тодорхой болгох.

[1] *Л.Эрдэнэцагаан.* Хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн өнөөгийн хэрэгжилт, практик. илтгэл.